

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025
ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙХ

АУДИТЫН КОД: ГСА-2025/60-ШТА-НА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа,
Утас: 70543156
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Аудитор: Б.Соёлмаа, Утас: 70543179
Цахим хаяг: soyolmaaba@audit.gov.mn

Говьсүмбэр аймаг

2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

АГУУЛГА 2

Аймаг, сумын ИТХ-ын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу, хуваарилсан байна. 7

1.1 Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд батлагдсан төсвийг бүрэн хуваарилж олгосон байна. 7

1.2 Аймгийн Сонгуулийн хорооноос батлагдсан төсвийг журмын дагуу хуваарилсан байна. 7

Зардлын эдийн засгийн ангилал хооронд дээд шатны байгууллагын шийдвэргүй зарцуулсан, зарцуулалтад тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна. 8

2.1 Унааны зардалд зарцуулсан шатахууныг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна. 8

2.2 Зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна. 9

2.3 Засгийн газрын нөөц хөрөнгөөс орон нутгийн 2025 оны нөхөн сонгуульд санхүүжилт хуваарилаагүй байна. 10

2.4 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна. ... 10

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Аудитор
Б.Соёлмаа

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 206 тоот

2025 оны 07 дугаар сар

Дүгнэлт

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
МТБ	Мэдээлэл технологийн байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СНЖ	Сонгогчийн нэрсийн жагсаалт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны А/44 дүгээр тушаалыг тус тус үндэслэн Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу нийцлийн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороо, бусад холбогдох байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
- Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам
- Батлагдсан төсөв, төсвийн хуваарь

Аудитын хамарсан
хүрээ:

Аудитад аймаг, сумдын Сонгуулийн хороо, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг MNS6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталж, 2021 оны А/81 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилт, дэд зорилт, асуудлын шинжилгээнд хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн, аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа:

Үндсэн мэдээлэл:

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, аудитор Б.Соёлмаа хийж гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 07 дугаар сарын 18-ний өдрөөс 07 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг боловсруулан, дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд 2025 оны 07 дугаар сарын 24-ны өдөр хүргүүлээ.

Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 04 сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор аймгийн сонгуулийн хороог байгуулсан. Шивээговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 11 дүгээр тогтоолоор сумын сонгуулийн хороог байгуулсан бөгөөд орон нутгийн 2025 оны нөхөн сонгуульд 29 төрийн албан хаагч томилогдон ажилласан байна.

Орон нутгийн 2025 оны нөхөн сонгуульд 1 нам, 1 нэр дэвшигч оролцсон байна.

Аймгийн Сонгуулийн хорооны даргаар аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ж.Оюунбилэг, нягтлан бодогчоор аймгийн СХДАГ-ын дарга Н.Алтанцэцэг нар томилогдсон байна.

Хүснэгт №1. Орон нутгийн 2025 оны нөхөн сонгуулиар хуваарилсан зардлын төсөв

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Хуваарилагдсан төсөв
1	Улсын бүртгэлийн хэлтэс	1,765.0
2	Аймгийн Сонгуулийн хороо	37,352.0
Нийт дүн		39,117.0

Хүснэгт товъёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
Хүснэгт 1	Аймгийн Сонгуулийн хорооны батлагдсан төсөв	7
Хүснэгт 2	Аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороонд хуваарилсан төсөв	8
Хүснэгт 3	Аймгийн Улсын бүртгэлийн хуваарилсан зардлын төсөв	8
Хүснэгт 4	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	9
Хүснэгт 5	Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	10

БҮЛЭГ 1

Аймаг, сумын ИТХ-ын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу хуваарилсан байна.

1.1 Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн Сонгуулийн хороонд батлагдсан төсвийг бүрэн хуваарилж олгосон байна.

СЕХ-ны Тамгын газрын даргын 2025 оны 1/177, 3/230, 3/273 дугаартай албан бичгээр аймгийн сонгуулийн хорооны санхүүжилтийн хуваарийг тайлбарын хамт тус тус хүргүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт №01 Аймгийн Сонгуулийн хорооны батлагдсан төсөв /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	2025.04.29	2025.05.23	2025.06.12
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	77.0	77.0	77.0
2	Сургалтын зардал	1,425.0	1,425.0	1,425.0
3	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны бичиг хэргийн зардал	450.0	450.0	450.0
4	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шуудан холбооны зардал	700.0	700.0	700.0
5	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны унааны зардал	1,360.0	1,360.0	1,360.0
6	Санал авах байр бэлтгэх зардал		300.0	300.0
7	Сурталчилгааны зардал		700.0	700.0
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал		4,888.0	4,888.0
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал		500.0	500.0
10	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх		140.0	140.0
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал хоолны зардал			19,443.2
12	МТБаг, даамлын урамшуулал, хоолны зардал			3,404.8
13	Томилолтын зардал			2,244.0
14	Шуурхай багийн зардал			1,720.0
	НИЙТ	4,012.0	10,540.0	37,352.0

Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын албан бичиг,

Аймгийн сонгуулийн хороонд орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбоотой санхүүжилтийн хуваарийг 3 удаа ирүүлсэн байна.

1.2 Аймгийн Сонгуулийн хорооноос батлагдсан төсвийг журмын дагуу хуваарилсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3-т заасан зардлуудад төсөв хуваарилсан байна.

Сумын сонгуулийн хорооны батлагдсан төсвийг зардлын нэр төрөл бүрээр харуулбал:

Хүснэгт №02 Аймгийн сонгуулийн хорооноос Шивээговь сумын сонгуулийн хороонд хуваарилсан төсөв / мянган төгрөгөөр /

№	Зардлын нэр	Төсөв	Суманд хуваарилсан төсөв
			Шивээговь сумын Сонгуулийн хороо

1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны бичиг хэргийн зардал	300.0	300.0
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шуудан холбооны зардал	400.0	400.0
3	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны унааны зардал	960.0	960.0
4	Санал авах байр бэлтгэх зардал	300.0	300.0
5	Сурталчилгааны зардал	700.0	700.0
6	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	140.0	140.0
7	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал хоолны зардал	13,395.2	13,395.2
8	Томилолтын зардал	660.0	660.0
	НИЙТ	16,855.2	16,855.2

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны даргын Захирамж 2025.06.05 №3, 2025.06.18 №14

Аудитаар аймаг, сумын төсвийн хуваарилалтыг “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын дагуу давтан тооцож үзэхэд зөрүү гараагүй.

Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой Улсын бүртгэлийн хэлтэст 1,765.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан хуваарилсан байна.

Төсвийн хуваарилалтыг зардлын нэр, төрлөөр задалж харуулбал:

Хүснэгт №03 Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төсөв

№	Зардлын нэр	/мянган төгрөгөөр/ Батлагдсан төсөв
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны мөнгөн урамшуулал	1,125.0
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх бичиг хэргийн зардал	600.0
3	Техник хэрэгсэл тээвэрлэх турших болон шуурхай багийн зардал	40.0
	Нийт дүн	1.765.0

Эх сурвалж: УБЕГ-ын 2025.05.07-ны өдрийн №А/82 дугаар тушаал

Хүснэгтээс харахад: УБХ-ийн нийт хуваарилагдсан төсвийн 63.7 хувийг мөнгөн урамшууллын зардал эзэлж байна.

БҮЛЭГ 2

Зардлын эдийн засгийн ангилал хооронд дээд шатны байгууллагын шийдвэргүй зарцуулсан, зарцуулалтад тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

2.1 Унааны зардалд зарцуулсан шатахууныг үр ашигтай, арвиан хэмнэлттэй зарцуулаагүй байна.

Аймгийн Сонгуулийн хороонд Орон нутгийн 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс нийт 37,352.0 мянган төгрөг батлагдсаныг бүрэн зарцуулсан байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороо нь шатахууны зардлыг олгохдоо гүйцэтгэх ажлын удирдамж, маршрут зэргийг урьдчилан баталж, гүйцэтгэлийн байдалд хяналт хэрэгжүүлдэггүй төсвийг үр ашигтай арвиан хэмнэлттэй зарцуулах бодлого баримтлаагүй, шатахууны зарцуулалтад тавих хяналт сул байна.

- Аймгийн сонгуулийн хорооны шатахуун зарцуулалтад тавих хяналт хангалтгүйгээс 250.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтыг тайлагнасан жолоочийн тооцооны хуудсыг давхардуулан бичсэн байна. Тухайлбал: Ланд-200 маркийн 0002 ГСА улсын дугаартай

автомашинаар 2025.06.24-ны өдөр Тагнуулын ажилтан санал тоолох төхөөрөмж СЕХ-нд хүлээлгэн өгсөн гэх боловч тухайн өдөр мөн аймгийн Сонгуулийн хорооны дарга уг автомашинаар тайлан мэдээг СЕХ-нд хүргэж өгч шатахуун зарцуулсан нь давхардал үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4², 13 дугаар зүйлийн 13.1³, 13.7⁴, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 20 дугаар зүйлийн 20.2.3⁵, 20.2.4⁶, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын НХМаягт ТМ-4, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 4 дүгээр зүйлийн 4.1⁷ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд жолоочийн тооцооны хуудсыг давхардуулан бичиж шатахуун зарцуулсан аймгийн сонгуулийн хорооны 250.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Хүснэгт №04 Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны мөнгөн урамшуулал	1,125.0	1,125.0	-
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх бичиг хэргийн зардал	600.0	600.0	-
3	Техник хэрэгсэл тээвэрлэх турших болон шуурхай багийн зардал	40.0	40.0	-
Нийт		1,765.0	1,765.0	-

Эх сурвалж: Аудиторын тооцоолол ажлын баримт, УБХ-ийн тайлан, анхан шатны баримт

Орон нутгийн 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлаас УБХ-т 1.765.0 мянган төгрөг хуваарилагдаж, 1.765.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулжээ.

2.2 Зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Аудитаар зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэхийг эдийн засгийн ангиллаар тулган шалгахад аймаг, сум, хорооны унааны зардалд 1,360.0 мянган төгрөг төлөвлөснөөс 1,560.0 мянган төгрөгийг зарцуулсан, томилолтын зардлыг 2,244.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 2,044.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- Шивээговь сумын сонгуулийн хорооны унааны зардалд 960.0 мянган төгрөг хуваарилагдсан боловч гүйцэтгэлээр 1,160.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулж, хуваарилсан төсвөөс 200.0 мянган төгрөгийг томилолтын зардлаас зардлын зүйл анги хооронд шилжүүлэн зарцуулсан

Зардлыг ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан нь Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.8-д “Сонгуулийн хороод

¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

² үнэн зөв байх

³ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.

⁴ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

⁵ холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах

⁶ нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах

⁷ Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө.

нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Энэ нь Сумын сонгуулийн хороо шаардлагатай зардлын зүйл ангилал хооронд зохицуулалт хийлгэх хүсэлтийг аймгийн Сонгуулийн хороондоо уламжлан шийдвэрлүүлээгүй, уялдаа холбоо сул, хяналтын тогтолцоо бүрдээгүй байгааг харуулж байна.

**Хүснэгт №05 Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын төлөвлөгөө,
гүйцэтгэл /мянган төгрөгөөр/**

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	77.0	77.0	
2	Сургалтын зардал	1,425.0	1,425.0	
3	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны бичиг хэргийн зардал	450.0	450.0	
4	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны шуудан холбооны зардал	700.0	700.0	
5	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны унааны зардал	1,360.0	1,560.0	(200.0)
6	Санал авах байр бэлтгэх зардал	300.0	300.0	
7	Сурталчилгааны зардал	700.0	700.0	
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал	4,888.0	4,888.0	
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	500.0	500.0	
10	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	140.0	140.0	
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал хоолны зардал	19,443.2	19,443.2	
12	МТБаг, даамлын урамшуулал, хоолны зардал	3,404.8	3,404.8	
13	Томилолтын зардал	2,244.0	2,044.0	200.0
14	Шуурхай багийн зардал	1,720.0	1,720.0	
НИЙТ		37,352.0	37,352.0	0

Эх сурвалж: Аудиторын тооцоолол ажлын баримт, АСХ-ны тайлан

Хүснэгтээс харахад: Батлагдсан төсвийг 100 хувь зарцуулж, буцаан төвлөрүүлсэн үлдэгдэл байхгүй байна.

2.3 Засгийн газрын нөөц хөрөнгөөс орон нутгийн 2025 оны нөхөн сонгуульд санхүүжилт хуваарилаагүй байна.

2.4 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих” журмын 3 дугаар зүйлийн 3.10⁸ заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй боловч хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар нийт 250.0 мянган төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоосон.

⁸ Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу, хуваарилсан байна.

- Нөхөн сонгуулийн зардлыг сумын сонгуулийн хороонд үндэслэлтэй хуваарилсан байна.

Шатахууны зардлыг үр ашигтай арвилан хэмнэлттэй зарцуулаагүй, зарцуулалтад тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

- Унааны зардалд зарцуулсан шатахууныг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.
- Зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна.
- Засгийн газрын нөөц хөрөнгөөс орон нутгийн 2025 оны нөхөн сонгуульд санхүүжилт хуваарилаагүй байна.
- Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 0/22

Чойр

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, "Эрх шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэхийг аудитор (Б.Соёлмаа)-д даалгасугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулж, биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Сонгуулийн хороо (Ж.Оюунбилэг)-нд зөвлөсүгэй.

4. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитор (Б.Соёлмаа)-д үүрэг болгосугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Б.Соёлмаа)-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.



Б.САРАНТУЯА

422501049